

**“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3 ДУГААР ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭЖИЖ БУЙ “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ,
ХУДАЛДАХ, АШИГЛАХ АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2100061/

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ:

Э.ЖАРГАЛСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Д.САНЧИРБАЯР

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ :



Б.ЭНХБАДРАЛ

БОЛОВСРУУЛСАН:

“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ АЖИЛТАН :

М.ДАВААЖАРГАЛ

Улаанбаатар хот
2026 он

ГАРЧИГ

| | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| НЭГ. УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ “ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ, АШИГЛАХ АГУУЛАХ”-ЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ----- | 3 |
| 1.1 Төслийн товч тодорхойлолт ----- | 3 |
| 1.2 Химийн бодисын агуулах ----- | 3 |
| ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ----- | 4 |
| 2.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл ----- | 4 |
| 2.1.1 Шууд нөлөөлөл ----- | 5 |
| 2.1.2 Шууд бус нөлөөлөл ----- | 5 |
| 2.2 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа ----- | 5 |
| 2.3 Нөлөөллийн эрчим ----- | 5 |
| 2.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ ----- | 5 |
| 2.5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ----- | 5 |
| ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ----- | 5 |
| ДӨРӨВ. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ----- | 6 |
| ТАВ. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө ----- | 8 |
| ЗУРГАА. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ----- | 9 |
| ДОЛОО. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө ----- | 10 |
| НАЙМ. Байгаль орчин- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ----- | 11 |
| ЕС. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөө ----- | 12 |
| АРАВ. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ----- | 14 |
| АРВАН НЭГ. Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн төлөвлөгөө ----- | 15 |
| АРВАН ХОЁР. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан нийт зардал ----- | 16 |
| Хавсралт ----- | 17 |
| Төслийн талбайн байршлын зураг ----- | 17 |
| Төслийн тоног төхөөрөмжийн ерөнхий байрлал ----- | 17 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|----------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1.Төслийн товч танилцуулга | 3 |
| Хүснэгт 2.Ажиллах хүчний мэдээлэл..... | 4 |
| Хүснэгт 3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал | 7 |
| Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал..... | 8 |
| Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт зардал | 9 |
| Хүснэгт 6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал..... | 10 |
| Хүснэгт 7.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал | 11 |
| Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал..... | 13 |
| Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал | 14 |
| Хүснэгт 10. БОМТөлөвлөгөөг тайлагнах хуваарь | 15 |
| Хүснэгт 11.2026 онд байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдэх ажлын нийт зардал | 16 |
| Хүснэгт 1. 2026 онд ашиглах, худалдах, импортлох химийн бодисын жагсаалт, хэмжээ, тоо ширхэг | 19 |

НЭГ. УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ,
АШИГЛАХ АГУУЛАХ”-ЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1.Төслийн товч танилцуулга

| д/д | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|-----|------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 |
| 1.1 | 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр | “Элемент” ХХК |
| | 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар | 9011082081 |
| | 3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл | Химийн бодис импортлох, хадгалах, худалдах, ашиглах агуулах |
| | 4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг | УБ хот Налайх дүүрэг 3-р хороо Хүчилтөрөгчийн гудамж |
| | 5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | Ерөнхий захирал З.Баярсайхан Утас: 99193790 Цахим хаяг: info@element.mn |
| | 6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг | Ерөнхий менежер Б.Ундармаа Утас: 88113666, 95576630 Цахим хаяг: undarmaab@element.mn |
| 1.2 | 1. Төслийн нэр | Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших “ЭЛЕМЕНТ” ХХК-ийн “Химийн бодис импортлох, хадгалах, худалдах, ашиглах агуулах”-ын төслийн |
| | 2. Төслийн харьяаллын байршил | Улаанбаатар хот, Налайх дүүрэг 3-р хороо |
| | 3. Төслийн ангилал | Жижиг дунд үйлдвэр |
| | 4. Төсөл эхэлсэн огноо | 2018 он |
| | 5. Төсөл хэрэгжих хугацаа | Хугацаагүй |
| | 6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт | 2020 оны 02-р сарын 10-ны өдөр тус байгууламжийн эмнэлэгийн аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр, агуулахын зориулалттай барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсан. Хүлээн аван комиссын дүгнэлт 2020 оны 4-р сарын 15-ны өдрийн 2020/194 тоот дүгнэлтээр баталгаажсан. |
| | 7. ТЭЗҮ баталсан огноо | 2019 он |

1.1 Төслийн товч тодорхойлолт

Улаанбаатар хотын хэмжээнд хагас жил тутамд 28000 кг эмгэг хог хаягдал, 2000кг химийн бодис, урвалж, 19000 кг эмийн хог хаягдал, 78000кг хурц үзүүр ирмэгтэй хаягдал, ойр орчмын ЭМБ-аас 32000кг нийт 154000кг хог хаягдал хүлээн авч устгах хүчин чадалтай. Эмнэлгийн хог хаягдлыг уурын автоклавт халдваргүйжүүлэн аюулгүй болгосны дараа овор хэмжээг багасгах зорилгоор бутлагчаар бутлаж ландфиллдэж устгана.

1.2 Химийн бодисын агуулах

Агуулахын барилга нь 137,5 м² гурван барилгаас бүрдэх бөгөөд агуулахын барилга нь нэг давхар, газраас хөрснөөс дээш 90см өргөгдсөн. Химийн бодисын агуулах нь үйлдвэрийн байрлалын зүүн хэсэгт байрлах бөгөөд хог устглын үйлдвэрээс 50м, гүний худгаас 61м, цахилгааны эх үүсвэрээс 75м зайнд байрлаж байгаа болно.



Хүснэгт 2. Ажиллах хүчний мэдээлэл

| № | Албан тушаал | Орон тоо |
|-------------------------------------|---------------------------------------------------|----------|
| 0 | 1 | 2 |
| Захиргааны хэлтэс | | |
| 1 | Ерөнхий захирал | 1 |
| 2 | Санхүү хариуцсан захирал | 1 |
| 3 | Ерөнхий нягтлан бодогч, Үйлдвэрлэл эрхэлсэн дарга | 1 |
| 4 | Ерөнхий менежер, Хүний нөөц | 1 |
| 5 | Санхүүгийн алба | 2 |
| Ариутгал халдваргүйжүүлэлтийн тасаг | | |
| 1 | Эрүүл ахуйч | 1 |
| 2 | Автоклавч | 2 |
| 3 | Угаагч | 2 |
| 4 | Бутлагч | 1 |
| Тээвэрлэлтийн алба | | |
| 1 | Тээвэрлэлтийн албаны дарга | 1 |
| 2 | Жолооч | 8 |
| 3 | Техникч | 7 |
| 4 | Лодер оператори | 1 |
| Инженер техникийн алба | | |
| 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан | 1 |
| 2 | Тоног төхөөрөмжийн инженер | 3 |
| 3 | Химич | 3 |
| 4 | Цахилгаанчин | 1 |
| 5 | Гагнуурчин | 3 |
| 6 | Туслах ажилтан | 6 |
| 7 | Харуул | 3 |
| Нийт | | 49 |

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлоход сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь хөрс, газрын гадарга, ургамал, амьтан байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг мөн хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дахаах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х” –ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөл (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

2.1.1 Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 13 (40.6%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, ургамлын бүтцийн өөрчлөлт, эвдрэл гарах, бэлчээр, агаар ба хөрсний бохирдол зэрэг нь шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

2.1.2 Шууд бус нөлөөлөл

Нийт нөлөөллийн 4 (12.5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Амьтдын орон зайн өөрчлөлт, гадаргын усны чанар, археологи, палеонтологийн олдворт шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна.

2.2 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатай.

2.3 Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөлөл нь дундаас бага байгаа ба нийт 17 нөлөөллөөс 8 нь дунд зэрэг, 9 нь сул нөлөөлөл бөгөөд 11 нь сөрөг, 6 нь эерэг нөлөөлөл байна. Иймээс байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаатай холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

2.4 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулсан болно.

2.5 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЭЛЕМЕНТ” ХХК нь хүний эрүүл мэнд болон Байгаль орчинд хор нөлөөгүй олонхын баримтлан ашиглаж байгаа зөвшөөрөгдсөн арга технологийг МУ-ын Хог хаягдлын хууль, Байгаль орчны холбогдох хуулиудад нийцүүлэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт болох Монгол Улсын

иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцлийг хангахад бидний гол зорилт оршино. Үүний дагуу 2026 онд дараах 5 чиглэлээр төлөвлөж ажиллаж байна.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
4. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө
5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
6. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө
7. Дүйцүүлэх хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
8. БОМТ ба түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөө

ДӨРӨВ. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

Хүснэгт 3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ мян.төг | Нийт зардал, мян.төг | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|----------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-------------|------------|-------------------------|----------------------|---------------|----------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгаалах арга хэмжээ | | | | | | | | |
| 1 | Ил задгай хог хаягдал шатаахгүй байх | Төслийн талбайд | Тогтмол | - | Үйл ажиллагааны зардал | | БО-ны ажилтан | Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS4585:2016 |
| 2 | Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, техникийг үзлэгт хамруулж, ялгарах хорт утаа, дуу чимээний түвшинг стандартад заасан хэмжээнд байлгах | | | | Үйл ажиллагааны зардал | | Инженер | |
| Усан орчныг амгаалах арга хэмжээ | | | | | | | | |
| 3 | Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/ | Төслийн нийт талбайн хэмжээнд | Ширхэг | 2 | 100.0 | 200.0 | Инженер | “Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” |
| 4 | Тоолууржуулах / шинээр худаг/ | | | 1 | 100.0 | 100.0 | | |
| Нийт дүн | | | | | | | | 300.0 |

ТАВ. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ мян.төг | Нийт зардал, төг /мян/ | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|---------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|-------------|------------|-------------------------|------------------------|----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Ахуйн хог хаягдал | | | | | | | | |
| 1 | Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх | Ойр орчмын 100 метр | Тогтмол | удаа | 280.0 | 280.0 | БО-ны ажилтан | Хог хаягдлын тухай хууль БОАЖ-ын сайдын А/433 тогтоол |
| 2 | Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх | Дахин ашиглагдах хог хаягдал | Тогтмол | удаа | 280.0 | 280.0 | Нярав | |
| 3 | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх | Хог хаягдлын цэгт | Тогтмол | удаа | 280.0 | 280.0 | БО-ны ажилтан | |
| 4 | Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх | Агуулахын ажилчдад | Тогтмол | удаа | 280.0 | 280.0 | БО-ны ажилтан | |
| Аюултай хог хаягдал | | | | | | | | |
| 5 | Химийн бодисын сав баглаа, боодол, асгарсан үед арчсан даавууг устгахдаа эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах | Төслийн талбайн хэмжээнд | Тогтмол | удаа | 280.0 | 280.0 | Химич | Хог хаягдлын тухай хууль ЗГ-ын А/173 тогтоол Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх журам |
| Нийт зардал | | | | | | | 1,400.0 | |

ЗУРГАА. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна. Төсөл хэрэгжүүлэгч нь ойролцоогоор 1999 м² талбайд ногоон байгууламжийг байгуулах шаардлагатай

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний нийт зардал

| № | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ мян.төг | Нийт зардал, /мян/ төг | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|------------------------------|-----------------------------------------|---------------------------------|-------------|------------|-------------------------|------------------------|---------------|-----------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Ногоон байгууламж бий болгох | | | | | | | | |
| 1 | Шинэс | Төслийн талбай | ш | 30 | 15.0 | 450.0 | БО-ны ажилтан | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль |
| 2 | Нарс | | ш | 20 | 15.0 | 300.0 | | |
| 3 | Монос | | ш | 9 | 15.0 | 135.0 | | |
| 4 | Буйлс | | ш | 9 | 15.0 | 135.0 | | |
| 5 | Наранцэцэг | | ш | 10 | 2.5 | 25.0 | | |
| 6 | Лили | Оффис | ш | 10 | 2.5 | 25.0 | | |
| 7 | Хар шороо | Нийт талбай | 1 машин | | 120.0 | 120.0 | | |
| 8 | Элс | | кг | 10 | 25.0 | 250.0 | | |
| 9 | Гумины бордоо | | литр | 8 | 7.5 | 60.0 | | |
| Хөрс бэлтгэх нүх бэлтгэх | | | | | | | | |
| 1 | /Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/ | Төслийн талбай мод бут тариална | Ажилчин | 2 | Үйл ажиллагааны зардал | | БО-ны ажилтан | Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS6260:2011 |
| Нийт дүн | | | | | | | | 1,500.0 |

ДОЛОО. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|--------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|-------------|------------|------------------------------------|----------------------|---------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Химийн бодис импортлох, хадгалах, худалдах, ашиглах агуулахаас 6 метрийн зайд тамхи татах, ил гал гаргаж болохгүйг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ бүхий бүс татах | Химийн бодис хадгалах агуулахын хэмжээнд | 1 бүс | 1 | 500.0 | | БО-ны ажилтан | MNS 5002:2000 "ХААЭА. Шуугтаны норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага" MNS ISO13688:2000 "ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага" MNS5390:2004"ХААЭА.Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS6458:2014. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага |
| 2 | Химийн бодис алдагдах, асгарах тохиолдолд (Хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого онгойлогч, наалддаг шошго, металл юлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэргийг) бэлэн иж бүрэн байлгах | | Иж бүрэн | 1 | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | Химич | |
| 3 | Агуулахад гал түймрийн үед хэрэглэх галын хор (10ширхэг), сараа байршуулах | | Иж бүрэн | 10ш | 52.8 | 528.0 | Б.О ажилчин | |
| 4 | Агуулахад термометр байршуулах | | ш | 1 | Гэрээт ажлын дүнгээр | | Гэрээт газар | |
| 5 | Ажилчдыг ХАБЭА-сургалтанд хамруулж дадлагажуулах | Төслийн нийт талбайн хэмжээнд | Жилд 1 удаа | | - | 372.0 | ХАБЭАА | |
| 6 | ХАБЭА-н шаардлага хангасан өвөл, зуны хувцсаар ажилчдыг иж бүрэн хангах | Бүх ажилчид хамрагдан | Иж бүрэн | | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | Нярав | |
| 7 | Ажилчдыг жил нэг удаа эрүүл мэндийн бүрэн оношилгоонд хамруулах | Бүх ажилчид хамрагдан | Жил 1 удаа | | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | Хүний нөөц | |
| Нийт зардал | | | | | | | | 1,400.0 |

НАЙМ. Байгаль орчин- Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Элемент” ХХК-ийн “Эмнэлэгийн тусгай хог хаягдал цуглуулах, устгах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд тус тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлах нь зүйтэй.

Мөн компанийн удирдлагын тушаалаар байгаль орчны асуудал хариуцсан ажилтныг томилох буюу тухайн асуудлыг хэн нэгэн албан тушаалтанд хариуцуулж эзэнтэй болговол зохино.

Ингэснээр уг ажилтан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаар компанийн захиргаа болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын өмнө хүлээх хариуцлагын орчин бүрдэнэ.

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хариуц агч | Баримтлах хууль, журам стандарт |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------|------------|--------------------------|----------------------|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Төслийн хүчин чадал энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх | Төслийн нийт талбай | Удаа | 1 | Үйл ажиллагааны зардал | | Гүйцэтгэх захирал | БОННУ-ий тухай хуулийн 7.4 БОНУ журам (ЗГ 374 тогтоолын 2-р хавсралт)-ын 4.13 заалт |
| 2 | Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах | Орон нутгийн иргэд | Удаа | 1 | Үйл ажиллагааны зардал | | Гүйцэтгэх захирал | Нийгмийн хариуцлагын гэрээ БОНБУ тухай хуулийн 14.1.3 |
| 3 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэж БОМТ биелэлтийг жил бүр дүгнүүлэх | БОННУ Т-гын хүрээнд | Удаа | 1 | Үйл ажиллагааны зардал | | БО-ны ажилтан | /БОАЖЯ-ны сайдын А-618 тушаал/ “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” |
| 4 | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх | БОННУ Т-гын хүрээнд | Удаа | 1 | | 1,900.0 | Гүйцэтгэх захирал | Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн онцгойлон анхаарах зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх |
| Нийт зардал | | | | | | | | 1,900.0 |

ЕС. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төлөвлөгөө

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, хяналт шинжилгээни дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэ тухайн оны эхэнд БОАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОАЖЯ болон УМХГ-т тайлагнана. Төслийн байгаль орчны нөлөөллийг тогтоохын тулд дараах хоёр бүсэд ОХШХ-ийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөлөөллийн цөм бүс
2. Нөлөөлөлд өртөгч бүс

Нөлөөллийн цөм бүс нь тухайн төслийн хэрэгжилт, хамрах талбайн хил заагаар хязгаарлагдана. Энэ хэсэгт ОХШХ-г туссан байгалийн объект бүрээс дээж авах ба нөлөөлөлд өртөгч бүс нь хамрагдах газрын заагаас гадагш бүх зүгт жигд тархалттай байх тул тус төслийн хувьд хамгийн ихдээ 1.0км байхаар тооцлоо. Энэ бүсэд ОХШХ-г туссан байгалийн объект бүрээс дээж авах шаардлагагүй ба тухайн төслийн онцлог, байгаль цаг уурын нөхцлөөс хамаарч 1 болон түүнээс олон тооны хяналтын цэг тогтоогдох боломжтой. Хяналтын цэгүүдийг сонгохдоо тухайн байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн онцлог, шилжилт хөдөлгөөн, төслийн нөлөөлөл, эрчим зэрэг хүчин зүйлийг харгалзана. ОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ хяналтын цэгүүдэд заагдсан хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ба хяналтын цэгүүдийн байршлыг өөрчлөх боломжтой.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал

| № | Хяналтын цэгийн байршил | Хамрах хүрээ Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|----------------|-------------------------|----------------------|---------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Агаарын чанар | | | | | | | |
| 1 | Химийн бодис импортлох, хадгалах, худалдах, ашиглах агуулахын байр дотор-1цэг Химийн бодис импортлох, хадгалах, худалдах, ашиглах агуулахын хашаан дотор-2 цэг | Жилд 4 удаа | 3цэгт | 49.5 төг | 148.5төг* 4 удаа | БО-ны ажилтан | MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага |
| Хөрс | | | | | | | |
| 2 | Төслийн талбайн ил гарсан хөрснөөс | Жилд 4 удаа | 5 цэгт | 45.0 | 225.0төг* 4 удаа | БО-ны ажилтан | MNS3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| Усны чанар | | | | | | | |
| 3 | Унд, ахуйн ус | Жилд 4 удаа | 1 цэгт | 42.0 | 42.0 | БО-ны ажилтан | MNS0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдал MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага |
| Нийт дүн | | | | | | | 1,536.0 |

АРАВ. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Шинжилгээний байршил: Налайх дүүрэг

Хяналтын хугацаа, давтамж: Жилд 1 удаа

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Лодер

Баримтлах стандарт, аргачлал:

Үр дүнгийн бүртгэл, тайлан:

Хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас гаргасан маягтаар гаргаж, зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулна. Судалгааны үр дүнг байгаль хамгаалах ажлын жилийн тайланд хавсаргаж, мэргэжлийн хяналтын байгууллага болон орон нутгийн засаг захиргаанд хүргүүлнэ.

Хүснэгт 9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал

| № | Нийгдэх ажил | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал, төг /мян/ | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|-------------|----------------------|-----------------------------|-------------|------------|------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Тэрбум модны хүрээнд | ЗДТГ-аас зааж өгсөн талбайд | ш | 100 | Модны төрлөөс хамааран төлбөр өөр байна. | ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд энэ онд багтаан зааж өгсөн талбайд тохирох олон наст мод авч өгнө. |
| Нийт зардал | | | | | | . |

АРВАН НЭГ. Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн төлөвлөгөө.

Хүснэгт 10. БОМТөлөвлөгөөг тайлагнах хуваарь

| № | БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр | Тайлагнах зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Хариуцагч | Баримтлах хууль, журам стандарт |
|-----------------|------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|------------------------|---------------------------------|---------------|----------------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Нийслэлийн Байгаль орчны газарт | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биеллтийн тайлан | Үйл ажиллагааны зардал | Жил бүрийн 11 сарын 01-ны дотор | БО-ны ажилтан | БОАЖЯ, НБОГ |
| 2 | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | БОМТайлан | Үйл ажиллагааны зардал | Жил бүр 11сарын 30 ны дотор | БО-ны ажилтан | Аймаг, нийслэлийн ЗД-ын захирамж |
| Нийт дүн | | | | | - | |

АРВАН ХОЁР. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан нийт зардал


Хүснэгт 11.2026 онд байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдэх ажлын нийт зардал

| № | Үзүүлэлтийн нэр | Зардлын төрөл, чиглэл | Зардалын хэмжээ (мян.төг) | |
|-----------------------------|--------------------------------------------|------------------------------------|------------------------------------------------------|---------|
| 1 | 2 | 3 | 4 | |
| 1 | Байгаль төлөвлөгөө | хамгаалах | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 300.0 |
| | | | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1 900.0 |
| | | | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 1 500.0 |
| | | | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1 400.0 |
| | | | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1 400.0 |
| | | | Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө | - |
| 2 | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1 536.0 | |
| Нийт зардал, мян.төг | | | 8 036.0 | |

Хавсралт

Төслийн талбайн байршлын зураг

Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Бүс нуур 12610 тоот



Төслийн тоног төхөөрөмжийн ерөнхий байрлал

Үйлдвэрийн үндсэн барилга нь 24x17.6м хэмжээтэй 1 давхар барилга баригдсан. Барилга нь төмөр карказтай, цутгамал төмөр бетон суурьтай бөгөөд дотоод зохион байгуулалтаар хог хаягдал боловсруулах заал нь 422м², халаалтын тогооны өрөө 55.35 м², цэвэр усны банкны өрөө 31.5 м² болно. Энэ онд шатаах зуух, аюултай хог хаягдлын ландфиллын барилга байгууламж баригдан туршилтын шатандаа явагдаж байна.

Химийн бодисын агуулахын барилгын 1-р хэсэг ашиглалтанд орж НМХГ-ын дүгнэлт авсан бөгөөд ашиглахад бэлэн болсонб.



| | | | |
|---|----------------------------|----|------------------------|
| 1 | Агуулахын барилга | 10 | Хяналтын хэсэг |
| 2 | Оффисын барилга | 11 | Хаягдал шатаах зуух |
| 3 | Сагсан бөмбөгийн талбай | 12 | Хөргөлтийн систем |
| 4 | Үйлдвэрийн барилга | 13 | Утаа шүүх систем |
| 5 | Усны нөөцийн савны барилга | 14 | Үнс булах талбай |
| 6 | Тогооны барилга | 15 | Машин ариутгалын хэсэг |
| 7 | Гүний худаг | 16 | Харуулын байр |
| 8 | Дэл өртөө | 17 | Бетон талбай |
| 9 | Түлш хадгалах хэсэг | | |

Хүснэгт 1. 2026 онд ашиглах, худалдах, импортлох химийн бодисын жагсаалт, хэмжээ, тоо ширхэг

| № | Монгол нэр | Олон улсын нэр | Томьёо | CAS дугаар | Зөвшөөрсөн хэмжээ 5жил/тн |
|----|-----------------------------|------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------|---------------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Азотын хий | Nitrogen gas | N ₂ | 7727-37-9 | 250 |
| 2 | Алтны баталгаажсан стандарт | Certified Standards of Au | Au | 7440-57-5 | 250 |
| 3 | Алюминон | Aluminon | C ₂₂ H ₂₃ N ₃ O ₉ | 569-58-4 | 10 |
| 4 | Ангижруулагч бодис | Epoxy embedding medium, hardener MNA | C ₁₀ H ₁₀ O ₃ | 25134-21-8 | 25 |
| 5 | Анионы полиакриламид | Hychem 307- Anionic acrylamide copolymer | (C ₃ H ₅ NO) _n | 9003-05-8 | 100 |
| 6 | Аскорбины хүчил | L ascorbic acid | C ₆ H ₈ O ₆ | 50-81-7 | 10 |
| 7 | Аммонийн бифторид | Ammonium hydrogen difluoride | NH ₄ HF ₂ | 1341-49-7 | 100 |
| 8 | Аммонийн иодид | Ammonium Iodide | NH ₄ I | 12027-06-4;PP | 25 |
| 9 | Аммонийн сульфат | Ammonium sulfate | (NH ₄) ₂ SO ₄ | 7783-20-2 | 100 |
| 10 | Аммонийн фторид | Ammonium flouride | NH ₄ F | 12125-01-8 | 100 |
| 11 | Ацетон | Acetone | CH ₃ COCH ₃ | 67-64-1 | 250 |
| 12 | Бутилийн спирт | Butanol | C ₉ H ₉ OH | 71-36-3 | 100 |
| 13 | Глицерин | Glycerol | C ₃ H ₈ O ₃ | 56-81-5 | 50 |
| 14 | Диэтилийн эфир | Diethyl ether | C ₄ H ₁₀ | 60-29-7 | 20 |
| 15 | Идэвхжүүлсэн нүүрс | Activetad carbon | C | 7440-44-0 | 20 |
| 16 | Индигокармин | Indigo carmine | C ₁₆ H ₈ N ₂ Na ₂ O ₈ S ₂ | 860-22-0 | 50 |
| 17 | Иод | Iodine | I ₂ | 7553-56-2 | 50 |
| 18 | Калийн амил ксантат | Potassium amyl xanthate /PAX/ | C ₆ H ₁₁ OS ₂ K | 2720-73-2 | 25 |
| 19 | Калийн феррицианид | Potassium ferricyanide | K ₃ Fe(CN) ₆ | 13746-66-2 | 100 |
| 20 | Калийн иодат | Potassium iodate | KIO ₃ | 7758-05-6 | 20 |
| 21 | Калийн гидроксид | Potassium hydroxide | KOH | 1310-58-3 | 50 |
| 22 | Кальцийн гидроксид | Calcium hydroxide | Ca(OH) ₂ | 1305-62-0 | 100 |
| 23 | Калийн ферроцианид | Potassium ferrocyanide | K ₄ Fe(CN) ₆ x 3H ₂ O | 13943-58-3 (anhydrous) 14459-95-1 (trihydrate) | 50 |
| 24 | Кальцийн гипохлорит | Calcium hypochlorite | Ca(ClO) ₂ | 7778-54-3 | 50 |
